

Хээрийн тагтаа

Нурмухаммет Ясин

2005.06.27

Орчуулагчийн тэмдэглэл: Нурмухаммет Ясин хэмээх залуу чөлөөт уран бүтээлч энэ өгүүллэгээ анх Кашигарын Утга Зохиол сэтгүүлийн 2004 оны 5-р дугаарт Уйгурчуудын дуу хоолойг олонд хүргэх гэж хэвлүүлжээ. Зохиогчийг түүнээс хойш Хятадын хараанд амьдарч байгаадаа туйлын сэтгэл дундуур байгаа хүмүүсийг тод томруун дүрсэлснийх нь төлөө хорьж цагдаж байгаа юм. Жилийн эхээр RFA(Азийн эрх чөлөөт радио) энэ өгүүллэгээс сэдэвлэсэн нэвтрүүлэг хийж Уйгурт цацсан билээ.

1-р бүлэг:

Би зүүдэлж байна уу эсвэл сэрүүн байна уу?

Би, гүн хөх тэнгэрт нисэж явах шиг. Би сэрүүн эсвэл зүүдэлж байгаагаа үл ялгана. Сэвшээ салхи даль жигүүрийг минь даван салхилахад зүрх сэтгэл минь хөөрөн бяр хүч амтагдана. Өглөөний тунгалаг туяа эцэс төгсгөлгүй мэт гийж алтан наран түмэн бодосыг тодосгон гийгүүлнэ. Энэ сайхан үзэмжийг хараад хөөрсөн сэтгэлийнхээ догдолоор улам өндөрт дүүллээ би.

Гүзээлзгэнэт нутаг маань алслан холдоод дэлхий ертөнц гэнэт хаяа тэлэн гүн хөх өнгийн хивс дэвссэн мэт харагдана.

Тэртээ доор айлын сууц хашаа үзэгдэн байна. Ойр хавиар бужигнах амьтас бодвол ээжийн хол яваарай гэж захидаг өнөөх хүн гэгч нь биз. Надад бол нэг их аймаар амьтан биш л байна, газрын бэтэг адил удаан мөлхөгч ийм юмнууд тэнгэрийг эзэгнэгч жигүүртэнээс хүчтэй байж яахин чадах? Ижий минь магад зөнжээ.

Би буруу бодож байж болох юм гэхдээ л тэд тийм айж сүрдмээр амьтад биш санагдана. Ээж маань хэлэхдээ тэднийг зальтай атгаг амьтад, биднийг харангуутаа л урхи тавьж бариад торонд хорьдог гэдэгсэн. Яаж тийм байж таарах вэ? Миний ухаан хүрч ойлгож чадахгүй ч байж болох юм. Гэтэл гэнэт надад хүмүүсийг илүү сайн харж мэдэж авмаар санагдаад доошилж дээгүүр нь эргэлдэж эхэллээ. “Хүний залиг тоолж барашгүй, атгаг санаагаа гэдсэндээ нууж явдаг, болгоомжгүйгээсээ болж босгоны боол нь болов оо” гэж ээж маань үргэлж захидагсан.

Гэнэт надад тэр атгаг санаа гээч юмыг нь үзмээр санагдлаа. Яагаад түүнээ гэдсэндээ нуудаг юм бол? Надад ойлгохын аргагүй байлаа.

Газарт

Би сууцнуудын дээгүүр эргэлдсээр аажим доошиллоо. Одоо доор байгаа юмс улам тодорч хүмүүс, тэдний үхэр, хонь, тахиа зэрэг өмнө нь огт үзээгүй амьтад харагдана. Ойр хавиар нэг сүрэг тагтаа нисч зарим нь модны мөчир дээр сууцгааж байна.

Ярианд оролцохоор би буулаа. Эсвэл түр амсхийх ч гэсэн байж магад. Тэрхэн мөчид миний мэдрэхүй самуурсан учраас одоо яг сайн санахгүй байна. Харин тэдний аж байдлыг мэдэхийг туйлаас их хүсэж байснаа л лавтай санаж байна.

Spirit – зүрх сэтгэл

Soul – оюун сэтгэл, сүнс сүлд?

“Чи хаанаас ирэв?” гэж нэг тагтаа надаас асуулаа. Тэр бусдаасаа насаар ахимаг боловч сүргийн тэргүүн нь гэж хэлэхээргүй. Нэгэнт би сүргийн гишүүн биш болохоор тэр хөгшиний хэн байх нь юуны хамаа вэ. Тиймээс би товчхон л “Би гүзээлзгэнэт эрэгээр нутагтай” гэв.

Тагтааны үлгэр эхлэв

"Би тэр газрын тухай буурал ааваасаа дуулж байсан юм байна, манай дээдэс тэндээс ирсэн юм гэдэг" гэж тэр хэлээд “тэндээс чинь наашаа хэдэн сар нисэж ирэхээр тийм хол гэж би бодсон юмсан. Бид нар тийм хол нисч чадахгүй. Чи төөрөөд ингэж хол ирээ юу?” гэв.

Миний хэдхэн өдөрт туулсан тэр багахан зайг туулж барахгүй болтлоо өтөлсөн юм байх даа? Харагдаж байгаагаасаа өчнөөн хөгшин ч юм билүү эсвэл бүр холын өөр гүзээлзгэнэт эрэгтэй андуурсан юм биш байгаа даа. Өвөг эцэг нь үнэхээр манай гүзээлзгэнэт эрэгээс ирсэн юм бол надтай хамаатан байж магад гэж бодсон боловч тэр тухайгаа дурдалгүй “Би төөрөөгүй ээ, нисэх сургууль хийж байгаад наашаа явахаар шийдсэн юм аа. Гэрээс гараад хэдэн өдөр нисэхдээ би хэлэн дээрээ юу ч тавьсангүй “ гэж би хариуллаа.

Сэтгэл оюун гэж юу юм?

Хөгшин тагтаа гайхширсан харцаар намайг хараад “Тэгвэл чи чинь хээрийн зэрлэг тагтаа юм байна. Биднийг та нар шиг зүрх зоригтой биш, суудаг мөчир, унтдаг торноосоо холдож сэтгэдэггүй гэгцгээдэг. Би энд насаараа амьдарч, эндээсээ холдож аялж байсангүй, тэгэхийн хэрэг ч байсангүй. Амарч суух мөчир, хоргодох тор байна. Бүхнийг надад бэлдээд өгчихдөг. Яах гэж бид эндээс явах юм? Зовж зүдрэх гэж үү? Бас дээрээс нь гэр бүл, үр хүүхдээ яах билээ. Хаа очно гэж явах вэ? Манай эзэд надад сайн ханддаг” гэж ярьлаа.

“Хүмүүсийг аймшигтай гэж ярихыг би сонссон юм байна. Хэрэв хүмүүс биднийг барих юм бол сэтгэл оюуныг маань боолчилдог гэсэн. Үнэн болов уу?” гэж асуув.

“Сэтгэл оюун ий? Сэтгэл оюун гэж юу юм бэ, өвөө? “ гэж миний дэргэд сууж байсан бага тагтаа асуулаа. Сэтгэл оюун гэж юу болох, бүр үгийг нь ч мэдэхгүй байгаа нь намайг үнэхээр гайхашруулав. Үр хүүхдэдээ энэ тагтаанууд юу сургана вэ? Сэтгэл оюунгүй, сэтгэл оюун гэж юу болох тухай ямар ч ойлголтгүй хорвоог туулна гэдэг үнэхээр утгагүй. Үүнийг ухаарахгүй мэдэхгүй ч үгүй байгаа юм байх даа? Сэтгэл оюун, эрх чөлөө гэдэгийг худалдаж авч эсвэл бэлэгэнд авч болдоггүй зүйл. Гуйж залбираад ч авч үл дөнгөнө.

Сэтгэлийн эрх чөлөө энэ тагтаануудад үнэхээр амин чухал хэрэгтэй билээ. Үүнгүйгээр амьд явах утгагүй атал тэдэнд ойлголт нь бүү хэл үг нь ч байхгүй аж.

Хөгшин тагтаа багынхаа толгойг илбээд “Би ч бас сэтгэл оюун гэж мэдэхгүй, буурал эцэгээсээ нэг удаа сонсож байсан юм байна. Буурал эцэг маань харин буурал ааваасаа сонсож байсан юм гэсэн. Элэнц маань бүр элэнцийн элэнцээсээ сонссон байж ч болох юм. Миний буурал аав хааяа “Бид нар сэтгэл оюунаа их эрт алдсан юм гэнэ билээ” гэдэг байсан, тэр сэтгэл оюун нь бодвол одоо энэ тагтааны хэлж байгаатай адил биз. Одоо бидэнд түүнийх нь сүүдэр ч үлдсэнгүй дээ” гэв.

Хөгшин тагтаа надад хандаж “Хүү минь, чи сэтгэл оюун гэж чухам юу болохыг мэдэх үү?” гэж асуулаа.

Тагтаануудын мэтгэлцээн

Өөрийнхөө эхлүүлсэн сэдвийн асуултанд шууд хариулж чадахгүйгээ мэдээд би хөшиж орхилоо. Эцэст нь арайхийж “Би үүнээс цааш мэдэхгүй, гэхдээ ээжийн минь хэлэхээр би аавынхаа эрэлхэг зоригийг өвлөсөн... эрийн цээнд хүрээд би лавтайяа сэтгэл оюун гэж юу болохыг бүрэн ухаарна” гэж хариуллаа.

“Аавын чинь зүрх сэтгэл чамд байгаа хэрэг. Ганц миний эцгийн үеийнхэн сэтгэл оюунаа алдсан биш, бүх л тагтаан сүрэг даяараа сэтгэл оюунгүй болжээ. Миний ээж надад сэтгэл оюуны тухай ярьж дурдаж байсан удаагүй, би ч үр хойчдоо энэ үгийг дуулгаж байсангүй. Тэгэхээр бид сэтгэл оюунгүй эринд нэгэнт орсон биз. Эртний сайхан цагийг эргүүлж авчирвал ямар сайхан байх болоо” гээд хөгшин тагтаа инээмсэглэн тааламжтайгаар нүдээ анин зүүрэх аядав.

“Сэтгэл оюунгүй бол тагтаа үеийн үед хүний боол болно. Хүн хүссэн цагтаа л чамайг хүнсээ болгочихож чадна. Суллаж тавьлаа ч гэсэн чи гэр бүл, нормын будаанаасаа холдож чадна гэж үү. Толгой хоргодох газар, бэлэн олдох хоолоо зүгээр л хаячихаж чадна гэж үү? Чадахгүй байсаар дахиад л хойч үе чинь боолчлогдоно. Та нарт удирдагч хэрэг болно, гэхдээ эхлээд оюун сэтгэлээ чөлөөл. Тэгвэл энэ юу юм гэдэгийг ухаарна. Та нар надтай хамт яваад ээжээс асуувал яасан юм?”

Одоо би оюун сэтгэлийн тухай хөгшин тагтаа бид хоёрын хэн нь сурч мэдэх хэрэгтэйг мэдэхээ болив. Хоёуланд маань хэрэгтэй бололтой.

“Өнөө маргаашгүй хадан гэртээ харих болсон надад тагтааны тор минь өлзийтэй биз ээ. Оюун сэтгэлийг би хаанаас гэж хайх болж байна? Хэрэв би оллоо гэхэд танихгүй ч биз. Олоод таньлаа гэхэд надад ямар тустай юм? Одоо байгаа амьдрал минь амгалан тайван, юу ч болдоггүй. Үнэ цэнийг нь мэдэхгүй юмны төлөө энэ амьдралаасаа яаж татгалзах билээ би?”

Би хэлсэн үгийг нь бодож үзлээ. Өнгөцхөндөө ухаалаг мэт боловч уг чанартаа буруу аж. Гэнэт өөрийн бодол ухаанаа гэсэн ийм тагтаа, ийм шувуудтай гүн ухаан хэлэлцэж байгаадаа би ичих шиг боллоо. Тэгээд явж ээжийгээ олж уулзахаар шийдэв.

Этгээд үгс эхийн сүүг¹ орлов

Энэ үед нэг сүрэг тагтаа бидний хажуугийн мөчир дээр бууцгаав. Хоорондоо ярилцах нь сонсогдох боловч надад ойлгогдох ганц ч үг алга. Өөрсдийнхөө эх хэлээр ярьж байгаа байх, манай нутагт хааяа бас ийм харийн тагтаа үзэгддэг билээ. Тэд холын гийчид үү? Эсвэл энэ хөгшин тагтааны хамаатан садан юм болов уу? Хэлж үл мэднэ. Тэд бас намайг яриандаа оролцуулах үгүйг ч бас хэлж эс мэднэ.

“Яаж байна, хүү минь” гэж хөгшин тагтаа бага тагтаанаасаа асуулаа.

“Сайнгүй ээ, би өлсөөд байна. Ээж минь намайг яагаад тэжээхээ больсон юм бэ?” гээд бага тагтаа үргэлжлүүлэн тагтааны хүнсний тухай ярих авч би эрдэнэ шиш юм уу эсвэл олс гэсэн үг л сонслоо. Тагтааны хоолны тухай миний мэдэхгүй маш олон үг хэрэглэх юм. Эдгээр тэжээвэр тагтаа үнэхээр жигтэй, миний мэдэхгүй маш олон үг хэрэглэнэ.

“Эх чинь удахгүй төрөх дүү нарт чинь шим тэжээл нөөцлөх гэж байгаа юм аа. Чи хүн ирж биднийг хооллохыг хүлээх хэрэгтэй” гэж өвгөн тагтаа хариуллаа.

¹ Биологийн хувьд тагтаанд сүүний булчирхай байхгүй байх, гэхдээ зохиогч нэгэнт сүү гэж бичсэн нь учиртай биз.

“Би хүлээж чадахгүй, би цөл хээрт нисэн хүрч өөртөө хоол хайсугай” гэж бага тагтаа зөрүүдлэв.

“Миний хүү, аан гэж бай. Тийшээ явбал чамд маш аюултай, чамайг хэн нэгэн нь бариад идчихнэ. Битгий яв, хүү минь.” Бага тагтаа түрүүний шийдмэг байдлаасаа ухарч байгаа бололтой. Ер нь энэ тагтаанууд энэ өвгөн тагтааны үгэнд ордог янзтай.

Торны амьдралтай эвлэрэхүй

Энэ сүрэг тагтаа өөрсдийг нь хэзээ хэзээгүй барьж идэж магадгүй хүмүүстэй хэнэг ч үгүй хамт амьдраад байгааг би ойлгохгүй байлаа. “Идэх” гэдэг үгийг би буруу ухаараа юм болов уу? Тэдний аялганд нь “халамжлах” гэсэнтэй адил утгатай байдаг байх. Манай хэлэнд орсон харь үг болоод би буруу ойлгосон байх. Гэхдээ л тагтаа бүр мэдэх л учиртай өргөн хэрэглэгддэг үг дээ. “Хүнд баригдаж идүүлэв” гэж ээж маань захьдагсан. Энэ тагтаанууд идүүлэхээс айдаг юм бол яаж хүмүүсийн дунд амьдарч чадаж байна? Магадгүй далавчтай гэдэгээ ч мартаад аль хэдийн дасал болсон тороо орхих дургүй болсон байх.

“Манай эзэн ямар хүн бэ?” гэж бага тагтаа хөгшин тагтаанаас асуув.

“Их сайн”

“Гэхдээ манай эзэн бусад хүн шиг л боломж гарвал биднийг барьж идэх байх”

“Тэр бол өөр хэрэг. Хүмүүс биднийг тэжээж тэтгэхийн тулд торонд байлгадаг, тиймээс хэрэгтэй үедээ биднийг идэх нь тэдний эрх. Биднийг барьж хүнсэндээ хэрэглэх нь хүн төрөлхтөний хэрэгцээ юм. Ийм л байх учиртай юм. Бидний дотроос ямар ч тагтаа энэ жам ёсыг эсэргүүцэх ёсгүй” гэж өвгөн шувуу эрс хариулав.

Хэн нь дайсан бэ?

Одоо би энд “идэх” гэдэг үг манай тэндэхтэй адилхан утгатайг мэдлээ. Хэдхэн мөчийн өмнө “идэх” гэдэг үг ямар утгатайг таах гэж оролдож байлаа. Одоо нэгэнт таах хэрэггүй болжээ.

“Гэхдээ манай эзэн бидний бүх хоолыг асгаад, тэгсэн чинь хамгийн том биетэй тагтаа бүгдийг нь идчихсэн. Өөрийнхөө хувийг хүртэхийн төлөө тэмцэл эхлүүлэх боломж надад байсангүй. Би яана вэ? Өдөр өдрөөр би турж эцэж байна. Ийм байдлаар удаан амьд явахгүй шүү дээ, би.”

“Чи бас өсөж томроод том тагтааны эрүүн доороос бага зэрэг будаа хулгайлж бас сурнаа гайгүй. Гэхдээ чи ямар ч тохиолдолд бусад идэх юм үлдээж болохгүй. Энд ингэж л амьд үлддэг юм.”

Оюун сэтгэлийн тухай маргалдав

“Гэхдээ өвөө —“ гээд бага тагтаа эхлэх гэтэл

“Одоо хангалттай, хүү минь. Илүү юм яриад хэрэггүй. Байгаадаа л сэтгэл хангалуун байхад тагтаанууд суралцах ёстой. Илүү юмны төлөө маргалдах гээд хэрэггүй.”

Илүү уудам ертөнц

Энэ үед би ярианд нь оролцох нь зүйтэй гэж бодоод үгийг нь таслав. “Та түүний эрх чөлөөг таслан хумижээ. Түүнд илүү өргөн орон зайг өгөх хэрэгтэй. Өөрийнх хүсэл зорилгоор амьдруул” гэж би үнэхээр тэсэж болсонгүй хэлчихэв. Өвгөн тагтааны хэлснээр явбал бүхий л тагтааны зүйл устах билээ.

“Чи бидний байдлыг юу гэж ойлгохов дээ” гэж өвгөн сөргөж байна. “Эзний уурыг хүргэх бол үнэхээр үл бүтэх хэрэг. Хэн нэг маань үгнээс нь зөрж газар нутагаас нь гарч явах юм бол үлдсэн бид бүгд торонд түгжигдэж хэдэн сараар сараалжны цаанаас дэмий л гөлөрцгөөнө. Сууж нарладаг ганц мөчрөөсөө хагацана шүү дээ.”

Тагтааны тор гээч ер нь юу байна? Надад наад захын ойлголт байсангүй. Энэ тагтаануудын хэлэхээр бол дотор нь орохоос үнэхээр айдаг мөртлөө бас салж холдож зүрхэлдэггүй юм байна. Хамгийн толгой эргүүлмээр нь эд нар хүмүүстэй нэг дор яаж байж чадаж байнаа. Би энэ тухай өөрийн буурал аавтайгаа хэлэлцэж байл уу? Тэр надад тодорхой хариулт өгсөн удаагүй санагдана.

Хариуд нь би хөгшин тагтаад ингэж хэлэв “Та яг тэр хүмүүсийн нэг шиг ярьж байна. Ядуу буурай тагтаанаас хоолыг нь булаачихаад эсэргүүцэл гаргахыг хориглож байдаг. Тэгээд өөрийн муу үйлээ нуухыг ихэд хичээнэ. Ийм орчинд ирдээдүй хойч чинь эрүүл торниун өсч чадах уу? Та муу санаандаа өмхөрсөн, мулгуу сохор юм.”

Тэрээр унтууцаж “Хүмүүсийг битгий доромжил. Тэдэнгүйгээр бид нар өнөөдөр энд орогнож байхгүй шүү дээ. Хүн төрөлтний эсрэг ухуулгаа өөр газар хий.”

Зөвхөн туслах л гэсэн, ямар ч хор хүргэх санаагүйг минь тэр яагаад анзаарсангүй вэ? Магадгүй би дэлгэрүүлэн тайбарлавал зохих байх.

Хувь заяаны зүүд

“Үүрэг хариуцлагын тухай танд ямар ч ойлголт алга, ийм амьдралаар бусдыг шийтгэж өөрийн үр хойчоо солигт гаргаж байна” гэж би үргэлжлүүлэн өөрийн санаагаа тодосгох гэсэн боловч гэнэт тасхийх чимээ гарч хөл минь аймшигтай өвдөхийг мэдрэв. Би нисэхийг хичээвч хоёр минь далавч хөдөлсөнгүй. Бүх тагтаа хөөрч нисээд дээгүүр эргэлдэнэ.

“Харж байна уу, яршиг татаад байхаар ингэдэг юм. Одоо чи торон дотор суухын зовлонг үзнээ гайгүй. Дараа нь чамайг энэ чигээрээ зөрүүдлэхийг чинь харъя” гэж нэг нь бархирна.

Одоо л мэдлээ. Хөгшин тагтаа намайг хуурч өөртөө ойртуулаад эзнээрээ бариулжээ. Зүрх минь зүсэгдэх шиг боллоо. Надад хүн биш харин өөрсдийнхөө ашигийн төлөө надаас урваж худалдсан төрөл садан минь илүү аюултай байжээ. Ойлгохын аргагүй юм, ямар гашуун юм бэ. Хэзээ ч бууж өгж болохгүй гэж би хатуу шийдлээ. Хөлөө хуга татаад ч болсон өөрийгөө чөлөөлж болно. Бүхий л хүчээ дайчлан нааш цааш нисэх гэж үзлээ.

“Хүү минь юу болов? Яав? Босооч” гэх ээжийн танил дотно дуу намайг сэрээлээ. Ээжийнхээ дөлгөөн харцыг хараад сая зүгээр байгаагаа мэдлээ.

Ээж минь “Чи хар дарж зүүдэлжээ” гэв. “Би ёстой муухай зүүд зүүдэллээ” гээд ээжийгээ тэврэн зүүдэндээ болсон явдлыг ярьлаа.

“Хүү минь, чи зүүдэндээ хувь заяагаа харжээ. Хүн төрөлхтөн биднийх байсан газар орныг бага багаар түрэн эзлэж биднийг шахсаар байна. Олон мянган жил оршсон нутгаас минь биднийг хөөж нутгийг минь булаан эзлэхийг хүсч байна. Тэд бидний өв уламжлалыг

өөрчилж, оюун мэдлэгийг минь цөлмөж эв эеийг минь эвдэхийг санаархаж байна. Биднийг хэн болохыг мартагнуулахыг оролдож байна. Удахгүй энд өндөр байшин, үйлдвэрийн газрууд барьж түүнээс нь гарсан хаягдал утаа байгаль дэлхийг минь бохирдуулж, газар усыг минь хордуулах биз. Одоо байгаа гол ус минь урьдынх шигээ тунгалаг сайхан байхгүй харин үйлдвэрийн хаягдалаар булингартаж харлан урсах биз”

Гүээлзгэнэт эрэгээс алслан гарлаа

“Хүний энэ түрэмгийлэл аюумшигтай байх болно. Хойч үе минь цэвэр агаар, цэнгэг ус гэж мэдэхгүй, тийм л байдлаараа байсан юм шиг бодох болно. Тэд хүний урхинд орно. Энэ хүмүүс улам л ойртох боллоо, удахгүй зугтах холдох ч газар олдохгүй биз. Биднийг энэ хувь зохиолоос хэн ч аврахгүй, бид өөрсдөө л өөрсдийгөө аврах ёстой. Гадаа гарья, одоо аавын чинь тухай хэлж өгөх цаг болсон.”

Ээж минь намайг дагуулж гарлаа. Бидний эргэн тойрон газар ногоон хивс, алаг цэцэгсээр хучигдсан ямар ч зам харгүй, хүний мөр гараагүй уудам их тал. Манай гэр голын хажуугийн өндөр эрэгэнд байх ба олон мянган тагтаа энд үүрлэдэг. Тэртээ доогуур дөлгөөхөн мөрөн доор урсах агаад нэгэн төрлийн бүүвэйн дуу дуулах шиг сонсогдоно. Надад бол ертөнцийн хамгийн сайхан, хамгийн амгалан газар энэ буюу. Хүн араатан гэтээгүйсэн бол бид энэ диваажиндаа өнө мөнхөд жаргах байсан сан.

Ээж минь хэлэхдээ “Энэ бол чиний төрсөн нутаг. Бас өвөг дээдсийн чинь нутаг. Чиний аав, бууралаав хоёр чинь хоёулаа тагтаан сүргийн тэргүүн байж энэ газраа улам сайхан болгож ирсэн. Тэдний хөдөлмөр, тэдний дуурсах алдар нь биднийг тагтаануудын дунд улам өндөрт өргөсөн юм. Нуруун дээрхи ачаа чинь хүнд шүү, чамайг аавынхаа шийрийг хатааж чадна гэж би найдна. Өглөө бүр чамайг би сургуулилуулж байлаа, өдөрт хэдэн зуун бээр нисэхийг заалаа. Булчин шөрмөс чинь чанга, ухаан чинь хурц болжээ одоо.”

“Бие чинь өсөж томорчээ, одоо сэтгэл оюун чинь гүйцэж өсөх ёстой. Үргэлжийн үргэлжид хүнээс болгоомжилж бай. Газраар явдаг амьтан болохоор аюулгүй гэж бодож болохгүй. Тэдэнд чинь буу гээч юм бий. Хэдэн зуун метрийн холоос буудаад унагаж чадна. Чи аавынхаа яаж өнгөрснийг мэдэх үү?”

“Үгүй. Та нэг удаа ярьж байгаад хэлэх цаг нь болоогүй гээд зогсчихсон” гэж би хариулав.

“За тэгвэл одоо цаг нь болсон. Хоёр гурван хоногийн өмнө энүүгээр хэдэн хүн эргэлдээд байхыг би ажигласан. Биднийг гярхай ажиж байна билээ. Буцаж ирэхээс нь өмнө бид аюулгүй газар олох хэрэгтэй. Аав чинь тэдний гарт үрэгдсэн юм шүү дээ.”

Бахархмаар удам судар

“Ээжээ тэр яаж хүний гарт орчихоо вэ хэлж өгөөч” гэхэд ээж маань бодол болон нүүрэндээ гуниг тодруулж

“Нэг удаа аав чинь хэсэг тагтаа дагуулж бидэнд хоол хүнс эрэхээр явсан юм. Ихэнхидээ тэд хоол ихтэй аюулгүй газар олж сонгодог байв. Аав чинь хүчирхэг хариуцлагатай удирдагч байсан болохоор аялал бүрийг ахалдаг байлаа. Энэ удаад бусдыгаа дагуулж яваад хэд хоносон боловч ирсэнгүй. Миний санаа ихэд зовж байлаа. Хагас өдрийн зайд хоол хүнс элбэгтэй газар олоод үүрээ нүүлгэдэг байсан юм. Гэрээсээ хол яваад тэгэж удаж байсан удаагүй байсан.”

"Би дотроо түүнийг осолджээ гэж мэдэж байлаа. Тэр үед чи болоод дүү нар чинь дөнгөж өндөгнөөсөө хагарсан байсан болохоор би гарч явж түүнийг хайх аргагүй байлаа. Хэдэн сарын дараа аавтай чинь хамт ниссэн нэг тагтаа эргэж ирэв. Аавыг чинь урхинд оржээ гэдэгт улам л итгэв. Бусад тагтаанууд уван цуван ирцгээв. Ганц ааваас чинь л сураггүй."

Энэ үе би ээжийгээ уйлж сэтгэлээр унах болов уу гэтэл харин нүдэнд нь зориг хатуужил гялалзаж байв.

"Аав чинь агуу сэтгэлтэй тагтааны хаан байсан. Өөрийгөө хамгаалж чадаагүй байж бусдыг яаж хамгаалах вэ? Хүнд баригдсан тагтаа буцан ирж хааны үүрэгээ үргэлжлүүлж яаж болох вэ? Хүмүүс түүнийг барьж хориход хааны удмынханы ёсоор тэр хэлээ тас хазсан. Тэр торонд дахиад нэг хором байж тэвчсэнгүй. Тор түүний цусанд будагдан улайсан гэдэг. Идэж уухгүй яг долоо хоног торонд амьдараад өөрийгөө тийн золиослосон юм. Түүний сэтгэл зүрх нь үнэхээр чөлөөтэй байсан юм шүү. Би чамайг яг аав шигээ эрх чөлөөг хамгаалагч болоосой гэж найдаж байна"

"Ээжээ, аав яагаад бусад тагтаа шиг зугтаах арга олоогүй юм бэ?"

Эрх чөлөө эсвэл үхэл

"Хүмүүс аавыг чинь өөр нэг тэжээмэл тагтаатай нийлж эрлийз үр төл гаргах болов уу гэж бодсон. Гэвч тэр боол шиг хориотой хэн нэгэнтэй хэзээ ч нийлэхгүй, нийлвэл түүнд дэндүү ичгэвтэр хэрэг болох байлаа. Чиний зүүдэндээ үзсэн тэр тагтаанууд бол боолчлолыг хүлээн зөвшөөрөгсөдийн үр хойч. Хүү минь, тэдний оюун сэтгэл нь ялтан шиг хориотой. Тэгэж амьд явсанаас мянган удаа үхсэн нь хамаагүй дээр шүү. Чи бол зоригт тагтааны үр. Аавынхаа зориг зүрхийг үхүүлэлгүй авч яв."

Ээжийн минь яриа миний оюун сэтгэлийг удтал донсолгов. Ийм эрэлхэг тагтааны үр гэдэгтээ хязгааргүй баярлаж бахархалаар бялхав. Зүрх минь чанга бөгөөд бардам болов. Зүрх сэтгэлийн гүнээс ээжийгээ хайрлан тэвэрлээ.

"Одоо чи явах ёстой. Би хүүгээсээ эх нутаг болоод бусад олон тагтааныхаа тусын тулд хагацъя. Сүргийнхээ сайн тэргүүлэгч байгаарай. Хүмүүс улам л харгис болж биднийг урхидаж барих бүхий л төрлийн арга хэрэглэх болжээ. Одоо явж бидний амьдрах аюулгүй газар ол, хүү минь"

Миний далавч ээжийн нулимсанд норжээ. Одоо миний зүүдний зөн тайлагдлаа, би аялалаар явах ёстой ажээ. Гэхдээ миний бодоход би яасан ч хүний урхинд орохгүй дээ.

Би улам улам холдон нислээ, эхлээд гол дагаж дараа нь хүмүүсийн бөөгнөрөн суудаг газраар. Миний зүүдэндээ үзсэнтэй огтхон ч адилгүй боловч би болгоомжилж улам дээшлэн нисэв. Жигүүр минь эрч хүчээр дүүрэн билээ. Би хүмүүсийн маргалдахыг бус салхины хөгжимдөхийг л сонсож явав.

Шинэ нутагийн эрэлд

Энэ хүмүүс чинь тийм ч хүчирхэг сүрдмээр биш л юм гэж би бодлоо. Хэтэрхий өндөрт нисч байгаад олох ёстой газраа харахгүй өнгөрөх вий гэж айлаа. Хэрэв хэт хол нисвэл бидний нүүх төлөвлөгөөнд саадтай. Манай гэр маш өндөр эрэгний элэгэнд байхад тагтаанд хүртэл амаргүй байдаг эрэг өөд хүн авирч чадна гэж үү? Бид энд үе дамжин амар жимэр жарган суусаар атал бидний санаснаас сул дорой хүнээс айж дассан газраа гэнэт

орхихын хэрэг юун? Ингэж бодохын үед яг доор хүний суурин харагдав. Надад өчүүхэн ч айдас төрсөнгүй. Ээж минь дэндүү их санаа зовдог байж ч болох юм.

Тэнгэр харанхуйллаа. Эргэн тойрон минь тас хар, ертөнц шөнийн харанхуйд нуугджээ. Би бүхэл өдөржин нисчихсэн байна, одоо амрах хэрэгтэй. Баруун, Хойд, Өмнөд зүгт эрсэн боловч нүүж очоод амьдарчихаар газар олсонгүй.

Би дэндүү өндөрт нисээд байсан ч байж магадгүй. Маргааш би Зүүн зүгт арай доогуур нисээд үзвэл дээр байх. Тэнгэрт түг түмэн одод гялалзахыг хараад ийм сайхан дэлхийд амьдрагч надад айхын хэрэг юу байна гэж бодогдлоо. Би алгуурхан доошилсоор нэгэн модон дээр буулаа. Маргааш сэрээд л хаана бууснаа харах байх. Тэгээд эрэлээ үргэлжлүүлэн ниснэ. Шинэ нутаг олж чадах байхаа гэж найдъя.

2-р хэсэг

Гайхаж шагширсан дуу шуу бага залуу миний хязгааргүй их ядарсан нэгний унтдаг амтат гүн нойрноос минь сэрээв. Нэг сүрэг тагтаа над дээр шавж далавчаа дэвэн шуугилдана. Надтай яг адилхан харагдах нь намайг алмайруулав. Эхлээд харахад миний зүүдэнд харсан шувуудтай адилхан боловч сайтар ажиглавал өөр байлаа.

Юуны өмнө гэдэс өлсөж байгаа тул идэх юм олох хэрэгтэй байв. Нөгөө тагтаануудаас идэх юм олж болох аюулгүй газар асуулаа. Тэд гэнэт чиглэлээ өөрчилж айлын гэрүүдээс холдон нисэв. Би ч дагалаа.

Өлсгөлөн гэдэс

"Та нар хаачих нь вэ?" гэж би ард явж байгаа нэгнээс нь асуув.

"Тээрмийн байр руу."

"Тэнд очоод яах юм?"

"Тагтааны хоол хайна"

"Та нар идэх юм хайгаа юу?"

"Тэгэхээр чи хээрийн тагтаа байх нь ээ?" гэж тэр хүйтнээр хариу асуулт тавив.

"Чи уг нь хээрийн тагтаа юу?"

"Тийм ээ би гүзээлзгэнэт эрэгийн гаралтай."

Тагтаа баригчид

Тээрэм дээр хүрч очиход сүрлэнд хучаастай буудайны том овоолго харагдав. Амт нь үнэхээр сайхны дээр энэ агуулахад нүүж ирж болмоор хүний ул мөр огт харагдахгүй байв. Бусад тагтаанууд тайван амгалан бөгөөд баяр жаргалтай харагдана. Энэ орчинд би тайвширч зориг ороод хонхолзох ходоодоо баясгахыг бодлоо.

Гадаад ертөнц ээжийн хэлсэнтэй огт адилгүй байлаа. Өмнөө байгаа буудайг тоншохоор урагшилав. Гэв гэнэт нэг хүчтэй юм хоолойг минь боов. Би яг л харавсан сум шиг нисэх

гэж оролдовч ямар нэгэн хүчин араас минь татаад болсонгүй. Нуугдахыг бодсон боловч чадсангүй зүг чиггүй тойрон эргэлдэж газарт татагдлаа.

Бүх тагтаа дээш нисэн тархаж би яг л зүүдэндээ үзсэн шиг тийм газарт унах нь гэж сандарлаа. Хүний гарт орлоо доо гэж харамсавч ойр хавьд хүн үл үзэгдэнэ. Хэдэн цаг өнгөрснийг бүү мэд тэндээс би холдож чадахгүй байсаар. Тэгэж байтал хоёр хүн ирж миний хүзүүний боолтыг тайлахад нэгэнт баригдсанаа сая мэдлээ.

"Хээрийн зэрлэг тагтаа шив дээ" гэж залуу нь хэлэв.

"Сайн бариарай, далавчийг нь дарж боохгүй бол нисээд явчина шүү" гэж насаар ахимаг нь анхааруулав. Тэгээд хоёулаа миний далавчийг боож хүзүүнээс минь бариад нүд рүү минь ширтэх ажээ.

"Хөөе, энэ чинь үнэхээр сайхан амьтан байна. Азтай байна шүү бид" гэж хижээл хүн нь намайг нүдэндээ ойртуулан сайн хараад хэлэв.

'Наадхаа суллагчид'

"Энэ хээрийн тагтаа бидэнд хэрэг болохгүй ээ. Суллаад явуулчих. Аль хэдийн хэлээ хазчихаж. Ийм тагтаа барьвал тавьж явуулахаас өөр арга байдаггүй юм. Ихэнхидээ сүргийн удирдагч тагтаа л ингэдэг юм" гэж ахимаг настай хүн нь хэлж байна.

"Ядаж эм тагтаатай нийлүүлж өндөгтэй больё л доо" гэж залуу нь хэдэрлэв.

"Ийм тагтааг бид байлгавал идэж уухгүй, үхэн үхтлээ эсэргүүцэн тэмцэнэ"

Залуу зөрүүдлэж "Барьчихаад зүгээр л тавьж явуулна гэж юу байсан юм".

"За тэгвэл дураараа л бол. Үнэн юм ярьж байсныг минь чи мэднээ гайгүй. Би бас нэг удаа ийм тагтаа бариад тавьж явуулаагүй чинь ганцхан долоо хоноод үхсэн юм даа."

Торон доторхи тарчлаан

"Би ч энийг номхруулчихаж чадна" гэж залуу тун итгэлтэй өгүүлэв.

Чи намайг номхруулж хэзээ ч чадахгүй гэж би дотроо бодлоо. Гэртээ харих аргаа олж л таарна. Эхийнхээ үгэнд оролгүй хүний урхинд орсондоо би ичиж байлаа. Үлдсэн бүх хүчээ шавхан нисэн холдож чадмаар санагдав. Гэсэн ч би газарт пидхийтэл уналаа.

"Муу амьтаныг дээ. Нэг далавчийг нь уяж амжсан байсан нь боллоо. Тэгээгүй бол зугтчих байлаа"

Намайг уутанд хийгээд нэг тийш нь авч явах гэж байгаа бололтой. Бодвол далавчийг минь боогоод торонд хийх биз. Төмөр сараалжны цаана бүгдээрээ нэг буланд шигдчихсэн хэдэн тагтаа.

"Их л өлссөн байгаад миний урхинд унаж дээ чи" гэж залуу хэлээд торны нэг буланд идэж уух юм тавив. Түүнийг тавиад холдохын зуурт нөгөө хэдэн тагтаа хоол хүнс рүү үхэн хатан зүтгэцгээв. Хамаг бие минь уурандаа шатаж хамаг хүчээрээ тор мөргөвөл энэ гутамшиг дуусгавар болох биз гэж бодогдов.

Гэвч далавч минь боолттой болохоор би хөдөлж эс чадна. Толгойгоо наран өөд жаахан өндийлгөөд ганцхан өдөр өнгөрөөд л хүний урхинд орлоо доо, хэрэв ээж минь намайг ийм байдалтай байгааг харвал юу гэх байсан бол гэж бодлоо. Тэгээд нарнаас дальдарч шаланд наалдав.

Идсэн ч гүй, идэгдсэн ч гүй

Зүүдэндээ би ээжийгээ гүн хөх тэнгэрээс намайг дуудаж байгаагаар харлаа. Аав минь гарч ирж байна, өндөр сүрлэг бөгөөд бахархмаар. Тэд намайг дуудахад би угтан ниссэн боловч тэд цаашаа явчих юм. Намайг нисэхээ зогсоход тэд бас зогсож байна. Би цангаж “Ээжээ ус ууя” гэж хашгирав.

Хүний дуунаар би дэмийрэхээ болилоо. “Энэ тагтаа ёстой гэжүүд юм. Энд тав хоносон боловч юу ч идсэнгүй” гэж хэлэх хүн бол өнөө намайг барьсан залуу байв.

"Би чамд тэжээгээд хэрэггүй гэж хэлээгүй юу?" гэж ахимаг настай нь унтууцаж байна.

"Хоол идэхгүй байвал энэ тагтаа лавтайяа үхнэ. Ингэснээс хүүхэддээ шөл хийж уулгавал дээр бус уу?"

Ахмад нь ёжтойгоор “Одоо чи наадхаасаа юу ч олж долоохгүй, шөл хийж уувал өвдөж ч магад. Зүгээр суллаад явуулчих. Ингэж удаанаар тагтаа үхэхийг харахад харамсмаар” гэж өгүүлэв.

"Суллаж тавьлаа гээд бидэнд бас ямар ашиг байна” гэж залуу хариулав.

'Энэ ерөөсөө сайн юманд хүрэхгүй'

"Энэ явдалаас сайн үр дагавар гарахгүй дээ”

"Бид нар шууд л энүүгээр шөл хийчих байсан юм” гэж хариулангаа залуу эр миний далавчны боолтыг авч торны шалан дээр тавив. Тэнгэрт нисэн гарна байх хэмээн би хамаг үлдсэн хүчээ шавхсан боловч төмөр утсан уяаг би дийлэхгүй ажээ.

Торны хаалгаар шурдхийн гарахыг хүсэвч бас л эс чадна. Энэ тор дотор нь орсон хэний ч эрх чөлөөг авч хаяад дахин хэзээ ч эргүүлж өгөхгүй харгислалдаа дэндүү боловсорсон юм байна.

Торны наана цаанах агаар чанартаа адил боловч торны энэ талын амьдрал магадгүй нөгөө ертөнцийх биз ээ. Энэ хорих төхөөрөмжийг бүтээсэн хэн ч байлаа гэсэн өөрт нь ямар ч тусгүй атал мань мэт өчүүхэн амьтадыг хорихоор шийдсэн хамгийн хатуу чулуун зүрхтэй үнэхээр хар гартай нэгэн. Биеийг минь дөнгөлөөд тэд миний оюун сэтгэлийг бооно гэж горьдсон байх. Би амиа егүүтгэхийг хүсэвч чадахгүй байгаа нь хамгийн муу хэрэг байв. “Арилсан дотортой хүмүүс та нар намайг сулла, үгүй бол алаад аль” гэж хашгирмаар байв.

Танил дотно үнэр үнэртэхэд үзвээс ээж минь миний өрөвдмөөр гэмтсэн даль, хугархай хошуу, зулгарч бутарсан өдийг минь зовниж гялалзсан нүдээрээ ээлжлэн харж байлаа.

Оюун сэтгэлээ чөлөөлсөн нь

"Өршөө ээж минь. Надад итгэсэн итгэлийг чинь эвдлээ би. Таны хүү байхад би тэнцсэнгүй дээ" гэж би яллагдсан гэмт хэрэгтэн шиг толгойгоо гудайлгав. Ээжийгээ ирэхээс өмнө би үхчихгүй яав даа?

"Чи өөрийн хийж чадах бүхнээ хийсэн. Одоо чи энийг дуусгах ёстой" гэж ээж минь хариулав.

"Гэхдээ ээжээ би чадахгүй. Би бол хүч тэнхээгүй болсон хоригдол. Үхэхийг хичнээн хүсэвч болохгүй байна."

"Тэр ойлгомжтой. Тийм л учраас би чамд эрх чөлөөг өгөхөөр ирсэн юм"

"Би эрх чөлөөтэй байх эрхгүй. Би таны хүү байх үнэ цэнээ алдсан. "

"Би чамд дахиад хэлэе. Би эрх чөлөөг чинь авчирсан. Чи миний эрэлхэг хүү хэвээрээ, чи боол шиг амьд явах биш харин нэр төртэй сайн үхэх эрхтэй" гээд над руу нэгэн зүйл хүнс дөхүүлэв.

Эрх чөлөөний их үнэ цэнэ

"Энэ бол хортой гүзээлзгэнийн төрлийг идвэл чи чөлөөлөгдөх болно. Сүргийнхээ нэр төрийг сэргээ. Үнэн эрх чөлөө зөвхөн маш өндөр үнээр олдодгийг санаж яв. Алив амаа нааш нь ойртуул"

Би ээжийгээ сүүлчийн удаа ширтлээ. Тэр тайван амгалан бөгөөд эрэлхэг зоригтой харагдана. Би гэмтсэн хошуугаа түүн рүү сунгалаа. Намайг хамгаалж, надад хоол олж өгч бас хүмүүст барьж өгсөн хошуу минь миний сүүлийн зэвсэг боллоо. Одоо энэ минь хатуу төмөртэй тэмцсэн бүтэлгүй тэмцэлийн золионд хэмхэрчээ.

Гүзээлзгэнийн хор судсаар минь эрх чөлөөний дуун шиг урсаж эцсийн эцэст сайн үхэж чадсан баярыг минь бүхий л биеэр минь дарааж байлаа. Оюун сэтгэл минь яг л гал шиг чөлөөтэй дүрэлзэн байгаа нь мэдрэгдэж байв.

Одоо надад бүх юм тод харагдана.. Тэнгэр гүн хөх хэвээрээ, байгаль дэлхий урьдын адил үзэсгэлэнтэй, бүх юм чимээгүй дөлгөөн. Торны ирмэгээр хэсэг тагтаа цуглаж намайг харж гайхан алмайрах бөлгөө.

Маралбеши тойрог
2004 оны 3 сарын 24

Англи хэл рүү орчуулсан: Азийн эрх чөлөө радиогийн Уйгур нэвтрүүлэгийн эрхлэгч Долкун Камбери. Редактор: Сара Жонсон-Хан. Интернетэд бэлдсэн: Луситта Муди

Монгол хэлэнд орчуулсан: С. Соёлболд. Монгол орчуулгын редактор: